



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 30

Мандалговь

**Г.Энхтайванг аймгийн Засаг даргын Тамгын
газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Гөлгөө овогтой Энхтайван 85.2 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Г.Энхтайваны холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



**Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалд
нэр дэвшүүлсэн Г.Энхтайваны тухай дүгнэлт**

1. Г.Энхтайван нь 1985 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 37 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2004-2008 онд Шинжлэх ухаан техникийн их сургуулийн КТМС-ийг Санхүүгийн менежмент мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, 2019-2021 онд Монгол Улсын Үндэсний их сургуулийг эрх зүйн магистр зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2009-2014 онд Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын төрийн сангийн мэргэжилтэн, 2014-2015 онд төрийн сангийн төлөөлөгч, 2015-2018 онд Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга, 2018-2021 онд Санхүүгийн хяналт аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, 2021 оноос аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
4. Г.Энхтайваны тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ